



ЖЕНКО ТУР  
БЮРО ХК



# 2016 ОНЫ ТАЙЛАН

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ  
ХУРАЛД ЗОРИУЛАВ

Тухлах газрыг та сонго  
Туулах замыг бид хөтөлье

## ХУРЛЫН МАТЕРИАЛЫН АГУУЛГА

• Хурлын дэг.....	3
• Эрхэм зорилго, зорилт.....	4
• Компанийн товч танилцуулга.....	5
• 2015 онд авсан шагнал.....	6-7
• 2015 оны үйл ажиллагааны тойм.....	8
• Борлуулалтын орлого.....	9-10
• Гадаад аяллын тайлан.....	11
• Дотоод аяллын тайлан.....	12-13
• Хүний нөөцийн тайлан.....	14
• Үйл ажиллагааны үр дүн.....	15
• ТУЗ-ийн гишүүдийн танилцуулга.....	16-20
• Санхүүгийн байдлын тайлан.....	21
• Орлогын дэлгэрэнгүй тайлан.....	22
• Аудитын хорооны дүгнэлт.....	23
• Компанийн ТУЗ-ийн үйл ажиллагааны тайлан.....	24
• Аудитын дүгнэлт.....	25-26
• 2016 оны үйл ажиллагааны төсөв төлөвлөгөө.....	27

## ХУРЛЫН ДЭГ .....

1. Хурлын ирцийг бүртгэх /ажлын хэсэг/	14:00-14:20
2. Хурлын ирцийг мэдээлэх /ажлын хэсэг/	5 мин
3. Хурлын даргыг сонгох	5 мин
4. Хурлын дарга хурлыг нээх, хурлаар хэлэлцэх асуудлууд болон хурлын дэгийг танилцуулах	5 мин
5. Хурлын дарга /ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийг танилцуулах/	5 мин
6. Компанийн 2015 оны үйл ажиллагааны болон ногдол ашиг хуваарилах, санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах /ТУЗ-ийн дарга/	20 мин
7. Аудитын хорооны дүгнэлт /Аудитын хорооны дарга/	10 мин
8. Компанийн үйл ажиллагааны 2015 оны төлөвлөгөө /Гүйцэтгэх захирал/	10 мин
9. Үг хэлэх, санал хураах	10 мин
10. Хурлын завсарлага	10 мин
11. Тооллогын комиссын тогтоолыг танилцуулах	20 мин
12. Хурлаас гарах шийдвэр, тогтоолыг танилцуулах	10 мин
13. Хурлыг хаах /Хурлын дарга/	5 мин



## ЭРХЭМ ЗОРИЛГО

Гадаад, дотоодын жуулчдын хүсэл сонирхол, эрэлтэд нийцсэн чанартай бүтээгдэхүүн үйлчилгээг үзүүлж, олон улсын түвшинд хүрсэн үндэсний тур оператор байх үндсэн зорилготой.

## 2016 ОНЫ ЗОРИЛГО

2016 онд бид борлуулалтын орлогыг 3.5 тэрбум төгрөгт хүргэх зорилт тавин ажиллаж байна.

## 2016 ОНЫ ЗОРИЛТУУД

- Үйлчилгээний нэр төрөл, дотоод аяллын багцаа чанаржуулах.
- Ази болон Европод төлөөлөгчийн газартай болж гадаад орноос ирэх жуулчдын тоог 30%-иар нэмэгдүүлэх.
- Чингис хааны морьт хөшөө болон 13-р зуун цогцолборын дотоод болон гадаад тохижилт засварын ажлуудыг хийх.
- Гадаад аяллын шинэ чиглэл болон шинэ төрөл гаргах.

## КОМПАНИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

“Женко Тур Бюро” компани нь 1997 онд байгуулагдсан бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооны 2006 оны 01 сарын 11-ний өдрийн 05 тоот тогтоолоор “Женко Тур Бюро” ХК болж өөрчлөгдөн зохион байгуулагдаж, өдгөө аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй Монголын аялал жуулчлалын салбарт тэргүүлэгч компаниудын нэг юм.

**2006.01.17**

Монголын Хөрөнгийн Биржид бүртгүүлэн Хувьцаат Компани болж анхны гүйлгээ хийв.








**2007.6 сард**

13-р зуун цогцолборын нээлтийн үйл ажиллагааг хийж анхны зочдоо хүлээн авав.

**2008.9 сард**

“Чингис хааны морьт хөшөө” цогцолборын нээлтийг хийв.

## ҮНДСЭН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧИГЛЭЛ

-  • Дотоод, Гадаад аялал
-  • Дотоод, Гадаадын шууд нислэг захиалах
-  • Бүх төрлийн тээврийн билет захиалах
-  • Зочид буудлын өрөө захиалах
-  • Гэр бааз
-  • Уламжлалт баяр наадам зохион байгуулах
-  • М. I. С. Е Хурал семинар зохион байгуулах

**2015 ОНД АВСАН ШАГНАЛ**



**“ENTREPRENEUR-2015”**

АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЛБАРЫН  
ОНЫ ОНЦЛОХ “ENTREPRENEUR-2015”  
ШАЛГАРЛАА.

Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимаас зохион байгуулдаг Монгол улсын нийгэм, эдийн засгийн хөгжилд бодитой хувь нэмрээ оруулж буй шилдэг аж ахуй нэгж, байгууллагууд, бизнес эрхлэгчдийг шалгаруулан өргөмжилдөг “ENTREPRENEUR-2015” Аялал жуулчлалын салбарын оны шилдгээр шалгарлаа.

Хөдөлмөрөөр хөгжлийн үрийг тарих их үйлсийн төлөө үр бүтээлтэй, идэвхи зүтгэлтэй, бодитой ажлыг зохион байгуулж, амжилт гарган Хөдөлмөрийн салбарын оны шилдэг шалгаруулах “Хөдөлмөрийн хүн танаа” шилдэг бүтээн байгуулалт шагналд Чингис хааны морьт хөшөө цогцолбор Монгол улсын хөдөлмөрийн яамнаас батламж гардан авлаа.



ЧИНГИС ХААНЫ МОРЬТ ХӨШӨВТ ЦОГЦОЛБОР  
ХӨДӨЛМӨРИЙН САЛБАРЫН ОНЫ ШИЛДЭГ  
ШАЛГАРУУЛАХ “ХӨДӨЛМӨРИЙН ХҮН ТАНАА”  
ШАГНАЛД НЭР ДЭВШИЖ ШИЛДЭГ БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ

**БАТЛАМЖ**  
ГАРДАН АВЛАА



МОНГОЛЫН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ШИЛДЭГ  
ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ “ЖЕНКО ТУР БЮРО” ХК  
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЛБАРЫН

**ШИЛДЭГ ТАТВАР ТӨЛӨГЧ**  
АЖ АХУЙН НЭГЖЭЭР ТОДОРЛОО.

Монголын аялал жуулчлалын шилдэг хөрөнгө оруулагч “Женко Тур Бюро” ХК Аялал жуулчлалын салбарын шилдэг татвар төлөгч аж ахуйн нэгжээр тодорлоо.

Монголын Бизнесийн 13 салбарын шилдэг байгууллагуудыг шалгаруулдаг Grandexpo-2015 арга хэмжээний санал асуулгын дүнгээр “Женко Тур Бюро” ХК 2015 оны шилдэг тур оператор, шилдэг жуулчны цогцолбор шагнал гардан авлаа.



МОНГОЛЫН БИЗНЕСИЙН 13 САЛБАРЫН  
ШИЛДЭГ БАЙГУУЛАГУУДЫГ ШАЛГАРУУЛДАГ  
GRANDEXPO-2015 ШАГНАЛААС  
“ЖЕНКО ТУР БЮРО” ХК

**ШИЛДЭГ ТУР ОПЕРАТОР**  
**ШИЛДЭГ ЖУУЛЧНЫ БААЗ**  
-ААР ШАЛГАРЛАА



МОНГОЛЫН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ШИЛДГҮҮДИЙГ ТОДРУУЛАХ  
“GOLDEN COMPASS” AWARDS “ААС  
2015 ОНЫ АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ШИЛДЭГ ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧААР  
“ЖЕНКО ТУР БЮРО” ХК-ИЙН  
ЧИНГИС ХААНЫ МОРЬТ ХӨШӨВТ ЦОГЦОЛБОР  
ШАЛГАРЛАА



Монголын Аялал Жуулчлалын салбарын оны шилдгүүдийг шалгаруулдаг #Golden\_Compass\_2015 арга хэмжээнээс #Аялал жуулчлалын шилдэг хөрөнгө оруулагчаар “Женко Тур Бюро” ХК-ийн “Чингис хааны морьт хөшөө” цогцолбор шалгарлаа.



## КОМПАНИЙН 2015 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОЙМ


Компани 2015 онд өссөн дүнгээр 2.9 тэрбум төгрөгийн борлуулалтын орлоготой, 2.87 тэрбум төгрөгийн зардалтай ажилласан. Үүнийг өмнөх онтой харьцуулахад орлого 119.5 сая төгрөгөөр буурсан буюу 96.1%-тай, зардал 144.4 сая төгрөгийн дутуу зарцуулалттай, 65.3 сая төгрөгийн цэвэр ашигтай ажиллажээ. Аялал жуулчлалын маркетингийн ажлын хүрээнд дотоод аяллыг дэмжих зорилгоор олон улсын томоохон экспо арга хэмжээнүүдэд оролцох, хөрш зэргэлдээ орны аялал жуулчлалын компаниудтай хамтын ажиллагааг өргөжүүлэхийн зэрэгцээ 2015 онд маркетингийн зардлыг бууруулахад онлайн маркетингийг түлхүү сонгож ажиллав. “Чингис Хааны Морьт Хөшөөт Цогцолбор” нь “Гиннесийн дэлхийн дээд амжилтууд-2016” номонд (131 дүгээр хуудсанд) 40 м өндөр хэмжээтэй “Хамгийн том морьтны хөшөө” гэж тэмдэглэгдсэн ба Монголын Оюуны Өмчийн Газрын даргын 2015 оны 10 сарын 26-ны өдрийн тушаалаар улсын бүртгэлд бүртгүүлж “Архитектурын бүтээл, уран баримал, уран барилга” бүтээлийн төрлөөр “Женко тур бюро” ХК нь уг бүтээлийн өмчлөгчөөр оюуны өмчийн гэрчилгээгээ авлаа.

## БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО

Борлуулалтын орлогод эзлэх зардал, ашгийн хувь /сүүлийн 7 жилээр/


### БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО (2009-2015)

(тэрбум.төг)



2015 онд нийт 2.9 тэрбум төгрөгийн орлого олсон бөгөөд энэ нь өмнөх онтой харьцуулахад 96.1%-тай буюу абсолют дүнгээр 119.5 сая төгрөгийн бууралттай гарчээ. Үүнд Дотоод аяллын борлуулалт өмнөх оноос 32%-аар буюу 176.7 сая төгрөгөөр буурсан нь гол нөлөөлөл болсон. Харин Чингис хааны морьт хөшөө цогцолборын борлуулалт 55.4 сая төгрөгөөр өсч 104.8%-тай, 13-р зуун цогцолборын борлуулалт 21.5 сая төгрөгөөр өсч 104.6%-тай байгаа бол Гадаад аяллын борлуулалт 19.7 сая төгрөгөөр буурч 97.8%-тай гарсан байна. Энэхүү графикаар компанийн 2009-2015 оны 7 жилийн борлуулалтын орлогыг борлуулалтын төрлөөр ангилан харуулсан. Эндээс үйл ажиллагааны төрөл тус бүр тогтвортой өсөж ирсэн боловч борлуулалтын өсөлтийн хурдац саарчээ. Дотоод аяллын борлуулалтын орлогын бууралт нь үйлчлүүлэгчдийн тоо 2014 онтой харьцуулахад 37.4% болтлоо буурсантай шууд хамааралтай байна.

### БОРЛУУЛАЛТАНД ЭЗЛЭХ ЗАРДАЛ, АШГИЙН ХУВЬ (2007-2015 он)




Зардал ашгийн хувийг он тус бүрээр харуулбал 2009-2012 онд нийт борлуулалтад эзлэх өртгийн хувь 39-60% байсан бол 2013 онд 95%, 2014 онд 86%, 2015 онд 89% болж өссөн. Энэ өртгийн хуваарилалттай холбоотой. Нийт зардлын хувьд авч үзвэл 2015 онд өртгийн өсөлт инфляци, валютын ханшийн өсөлтийн нөлөөгөөр үйлчилгээний өртөг өндөртэй үйл ажиллагаа явуулсан нь харагдаж байна. Борлуулалтанд эзлэх үйл ажиллагааны зардлын хувь 2015 онд өмнөх оноос 4%-иар буурсан, ашиг 2%-тай байгаа нь үйлчилгээний өртөг нэмэгдсэн ч ашгийн хувь өссөнийг харуулж байна.

### ГАДААД АЯЛЫН ТАЙЛАН

Гадаад аялал 862.7 сая төгрөгийн борлуулалтын орлоготой, 738.4 сая төгрөгийн өртөгтэй, 124.3 сая төгрөгийн нийт ашигтай ажилласан харагдаж байна. Өмнөх оноос борлуулалтын орлогыг 19.7 сая төгрөгөөр бууруулж, өртгийг 8.1 сая төгрөгөөр нэмэгдүүлснээр, нийт ашгийг 27.9 сая төгрөгөөр бууруулсан үзүүлэлттэй байна. 2015 онд бүтээгдэхүүний төрлийг нэмэгдүүлсэн ба хэрэглэгчид хямд үнэтэй аяллыг сонгож үйлчлүүлэх хандлагатай байсан тул Орос, Хятад хөрш улсын зах зээлд түлхүү нэвтрэх бодлого барьж ажилласан байна.

Тус аялагчдыг үнийн дүнгээр нь ангилбал:  
 50% нь 1,500,000₮ буюу түүнээс дээш үнэтэй нислэгтэй аялал  
 50% нь 700,000₮ буюу түүнээс доош үнэтэй автобустай аялал

### Жуулчдын идэвхитэй аялсан газрууд





## ДОТООД АЯЛЛЫН ТАЙЛАН

374.9 сая төгрөгийн борлуулалтын орлоготой, 239.1 сая төгрөгийн өртөгтэй, 135.8 сая төгрөгийн нийт ашигтай ажилласан байна. Өмнөх оноос борлуулалтын орлого 176.7 сая төгрөгөөр буурсан боловч, өртгийг 238.8 сая төгрөгөөр бууруулснаар, нийт ашгийг 62.1 сая төгрөгөөр өсгөсөн үзүүлэлттэй байна. Энэ нь 2015 онд аялагчдын тоо өмнөх жилээс цөөн байсантай холбоотой бөгөөд Чингис хааны морьт хөшөөт цогцолборт 4 удаа, XIII зуун цогцолборт 2 удаа, Налайх дүүрэгт 1 удаа тус тус гадаад аялагчдад зориулсан бэсрэг наадам, арга хэмжээг зохион байгуулснаас дотоод аяллын ажлын үр дүнг харж болно.


Хугацаа (сараар)	1 сар	2 сар	3 сар	4 сар	5 сар	6 сар	7 сар	8 сар	9 сар	10 сар	11 сар	12 сар	2015 он	Өсөлтийн хувь	2014 он	2013 он	2012 он
Чингис Хааны Хөшөөт Цогцолбор	8,290	3,313	6,660	5,518	9,085	28,159	26,203	26,395	8,615	8,222	4,737	2,293	137,490	104%	132,073	95,885	90,555
XIII зуун цогцолбор	210	54	137	222	471	1712	2,444	2,446	974	323	246	117	9,356	115%	8,106	7,773	7,697
Дотоод аялал	5	-	-	19	27	553	45	215	406	5	2	-	1,277	279%	458	214	643
Гадаад аялал	13	83	-	13	-	-	-	-	35	21	11	21	197	6%	3,318	895	895
Гадаад аялал	250	87	63	43	229	121	164	0	58	29	0	69	1,113	381%	292	895	895
<b>2015 оны тоо</b>	<b>8,768</b>	<b>3,537</b>	<b>6,860</b>	<b>5,815</b>	<b>9,812</b>	<b>30,545</b>	<b>28,856</b>	<b>29,056</b>	<b>10,088</b>	<b>8,600</b>	<b>4,996</b>	<b>2,500</b>	<b>149,433</b>	<b>104%</b>	<b>144,247</b>	<b>104,767</b>	<b>98,895</b>
Өсөлтийн хувь	184%	76%	82%	62%	87%	169%	98%	100%	70%	85%	209%	124%	104%				

2014 оны тоо	4,765	4,644	8,392	9,419	11,311	18,121	29,454	29,185	14,402	10,154	2,391	2,009	144,247
2013 оны тоо	315	174	742	1,841	3,097	16,537	28,780	25,576	10,271	7,321	6,651	3,462	104,767
2012 оны тоо	65	95	601	1,745	2,805	16,292	28,308	25,400	10,165	7,350	4,015	2,054	98,895


## 2015 ОНД ЗОХИОГДСОН ЭВЕНТУУД

Сар	Эвентийн нэр	Хугацаа
1	Шинийн нэгний Нар харах аялал	2015
2	Мартын-8 Эмэгтэйчүүдийн баяр	2015
3	Түүхийн лекцтэй аялал	2015
4	"OPEN SEASON"	2015
5	Эх үрсийн баяр	2015
6	Номадик фейшн шоу	2015
7	Хүннү мюзик фестиваль	2015
8	Драмын театр "Тэнгэрийн хүү жүжиг"	2015
9	Genco Mongolian Bike Challenge	2015
10	Монгол хурим	2015
11	Чингис фестиваль	2015
12	Мөнгөн үдэш	2015

### 2015 онд ирсэн жуулчид улсаар



### Жуулчдын гол зорих газрууд




## ХҮНИЙ НӨӨЦИЙН ТАЙЛАН

Хүний нөөцийн зорилго:

Мэргэшсэн, чадварлаг хүний нөөцийг чухалчлах, ажилтнуудын ур чадварыг дээшлүүлэх, ажиллагсдын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, хамтын ажиллагаа, нэгдмэл байдал, багийн сэтгэлгээг эрхэмлэх.

2015 онд хийхээр зорьсон зорилтуудын хүрээнд хийгдсэн ажлуудыг гүйцэтгэснээр доорх үр дүнд хүрсэн гэж дүгнэж байна. 1. Байгууллага хүний нөөцийн тоонд биш чанарт анхаарсан. Үүний үр дүнд нийт үндсэн 10 ажлын байрыг гэрээт ажлын байрлуу шилжүүлсэн ба гэрээтээр ажилтан авч ажиллуулах. 2. Ажилтнуудын бүтээмж дээшилсэн, ажилдаа хандах хандлага нь нэмэгдсэн. 3. Хөдөлмөрийн зах зээл дээрх ажилгүй иргэдийг ажлын байраар хангасан. 4. Ажилтнуудын ажлын ур чадвар нэмэгдсэн. Бүтээмж дээшилсэн.

### ХҮЙСИЙН ХАРЬЦАА /НИЙТ АЖИЛТНААР/



## ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН

Үзүүлэлт	2008 он	2009 он	2010 он	2011 он	2012 он	2013 он	2014 он	2015 он
Ажиллагсдын дундаж тоо	43	58	62	73	68	59	65	68
Үндсэн хөрөнгө (мян.төг)	5,991.2	7,020.2	4,611.6	7,772.4	7,515.9	8,256.5	8,321.0	9,739.0
Нэгж хувьцаанд олгосон ногдол ашиг (төг)	1	1.2	1.3	1.5	1.6	-	-	-
Олгохоор тооцсон ногдол ашиг (сая.төг)	70	96	100	120	128	-	-	-
Нэгж хувьцааны зах зээлийн дундаж ханш (төг)	206	100	111	94.6	90	86.7	86.4	86.0

### ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2016 оны 02 сарын 18

№ 03/2016

Улаанбаатар хот

Ногдол ашиг хуваарилах тухай

“Женко тур бюро” Хувьцаат компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлаас ТОГТООХ НЬ:

1. Компанийн тухай хуулийн 46.6; 47.1.1 болон 76.1.12-р заалтыг үндэслэн ногдол ашиг хуваарилахгүйгээр тогтоосугай.

ТУЗ-ИЙН ДАРГА

Ж.БАТТӨР



## ТУЗ -ИЙН ХАРААТ БУС ГИШҮҮДИЙН ТАНИЛЦУУЛГА

### 1. Жамьянсүрэн БАТТӨР

<b>Төрсөн он сар</b>	1958
<b>Төрсөн газар</b>	Улаанбаатар хот
<b>Гэр бүлийн байдал</b>	Ам бүл 4, эхнэр хүүхэд хамт
<b>Боловсрол</b>	1976-1981 онд Цэргийн нэгдсэн дээд сургууль
<b>Мэргэжил</b>	Цэргийн улс төрч
<b>Ажиллаж байсан байгууллага</b>	Ардын армийн 162-р анги, ХЗЭ-ийн хорооны нарийн бичгийн дарга. 1984-1986 онд Ардын армийн 221-р анги,

ХЗЭ -ийн хорооны нарийн бичгийн дарга.

1986-1990 онд Барилгын цэргийн ерөнхий газар, ХЗЭ-ийн хорооны нарийн бичгийн дарга. 1990-1996 онд Мон трейд компанийн захирал, 1996-2000 онд “ДФ” ХХК-ийн захирал, 2000 оноос одоог хүртэл “Мабел” ХХК-ийн захирал. 2006 оноос одоог хүртэл С1 телевизийн Гүйцэтгэх захирал, МАХ-Импэкс компанийн ТУЗ-ийн гишүүн

**Гадаад хэлний мэдлэг:** Орос, Англи

### 2. Данзан ДАЯНБИЛГҮҮН

<b>Төрсөн он сар</b>	1976
<b>Төрсөн газар</b>	Улаанбаатар хот
<b>Гэр бүлийн байдал</b>	Ам бүл 4, эхнэр хүүхэд хамт
<b>Боловсрол</b>	1994-1998 онд Европ хэлний дээд сургууль, 2003-2005 онд СЭЗДС
<b>Мэргэжил</b>	Бизнесийн эдийн засагч, Бизнесийн удирдлагын магистр
<b>Ажиллаж байсан байгууллага</b>	1993-1994 онд Эдийн тэнгэр банк, оператор нягтлан бодогч, 1994-1997 онд УИХ-н Тамгын газар, Гишүүн туслах, 1997 оноос одоог хүртэл “Би Ди сек” ХК-ийн Гүйцэтгэх захирал
<b>Гадаад хэлний мэдлэг</b>	Орос, Англи

### 3. Бүрэнмэнд ЛХАГВАДОРЖ

<b>Төрсөн он сар</b>	1976
<b>Төрсөн газар</b>	Улаанбаатар хот
<b>Гэр бүлийн байдал</b>	Ам бүл 4, эхнэр хүүхэд хамт
<b>Боловсрол</b>	1993-1997 онд Техникийн их сургууль
<b>Мэргэжил</b>	Нефтийн инженер
<b>Ажиллаж байсан байгууллага</b>	1997 оноос одоог хүртэл, “Би Ди Сек” ХК-д дилер, дэд захирал
<b>Гадаад хэлний мэдлэг</b>	Орос, Англи

## ТУЗ -ИЙН ЭНГИЙН ГИШҮҮДИЙН ТАНИЛЦУУЛГА

### 4. Бадаан БАТБААТАР

<b>Төрсөн он сар</b>	1977
<b>Төрсөн газар</b>	Варшав хот
<b>Гэр бүлийн байдал</b>	Ам бүл 2.
<b>Боловсрол</b>	1993-1997 онд Техникийн их сургууль АНУ-ын Жеймс Медисоны их сургуулийг төгссөн. Жорж Вашингтон их сургуульд бизнесийн удирдлагын мастерийн зэрэг хамгаалсан
<b>Мэргэжил</b>	Бизнесийн эдийн засагч, Бизнесийн удирдлагын магистр
<b>Ажиллаж байсан байгууллага</b>	МСС хөрөнгө оруулалтын банкны дэд ерөнхийлөгч, Мянганы сорилын санд эдийн засагч, Си Си Пи хөрөнгө оруулалтын банкинд Санхүү эрхэлсэн дэд захирлаар ажиллаж байсан. 2010 оноос Firebird хөрөнгө оруулалтын сангийн зөвлөх, Си Би Эм ХХК-ийн Ерөнхий захирал, 2011 оноос Багануур ХК, Шарын гол ХК, Нако түлш ХК, Женко тур бюро ХК, Монгол шилтгээн ХК-ийн ТУЗ-ийн гишүүн, Бэрх уул ХК, Хот девелопмент ХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар ажиллаж байна.
<b>Гадаад хэлний мэдлэг</b>	Орос, Англи

## 5. Халтмаа ЦЭНДБАЯР

<b>Төрсөн он сар</b>	1960
<b>Төрсөн газар</b>	Улаанбаатар хот
<b>Гэр бүлийн байдал</b>	Ам бүл 4.
<b>Боловсрол</b>	1979-1983 онд Багшийн сургууль 1996-1997 онд Удирдлагын академид багш
<b>Мэргэжил</b>	Багш
<b>Ажиллаж байсан байгууллага</b>	1985-1998 онд 34-р сургууль багш 1996-1998 онд “Женко” ХХК менежер 1998-2002 онд “Country side” ХХК захирал 2002 оноос хойш Баянгол зочид буудал рестораны менежер, Гүйцэтгэх захирал
<b>Гадаад хэлний мэдлэг</b>	Орос

## 6. Баттулга НАМУУН

<b>Төрсөн он сар</b>	1988
<b>Төрсөн газар</b>	Улаанбаатар хот
<b>Гэр бүлийн байдал</b>	Ам бүл 2
<b>Боловсрол</b>	2007 онд Raffles college, Бизнес удирдлага, маркетинг
<b>Мэргэжил</b>	2008 онд Wales University, урлагийн бакалавр
<b>Ажиллаж байсан байгууллага</b>	Бизнес удирдлага, маркетинг 2005-2007 онуудад Баянгол зочид буудал, С1 телевиз, Richard Mille Singapore зэрэгт маркетингийн менежер 2008 – Industrial corporation of Mongolia –д төслийн менежер 2011 оноос одоог хүртэл “Женко Тур Бюро” ХК-ийн Гүйцэтгэх захирал
<b>Гадаад хэлний мэдлэг</b>	Англи, Хятад

## 7. Цэнд ЭНХТУЯА

<b>Төрсөн он сар</b>	1962
<b>Төрсөн газар</b>	Улаанбаатар хот
<b>Гэр бүлийн байдал</b>	Ам бүл 6.
<b>Боловсрол</b>	1978-1982 онд Дүрслэх урлагийн дунд сургууль 1991-1993 онд Дүрслэх урлагийн дээд сургууль
<b>Мэргэжил</b>	2005-2006 онд Удирдлагын академи
<b>Ажиллаж байсан Байгууллага</b>	2004-2006 онд СЭЗДС Зураач 1983-1990 онд Дуурь бүжгийн академик театрт зураач 1990-1992 онд “Тамир” ХЭАА менежер 1992-1994 онд “Женко” ХХК нарийн бичиг 1994 оноос одоо хүртэл “Нүүдэл трейд” ХХК захирал
<b>Гадаад хэлний мэдлэг</b>	Англи, Орос

## 8. Дашцэрэн ДАВААСҮРЭН

<b>Төрсөн он сар</b>	1966
<b>Төрсөн газар</b>	Улаанбаатар хот
<b>Гэр бүлийн байдал</b>	Ам бүл 4.
<b>Боловсрол</b>	1986-1990 онд Цэргийн дээд сургууль 2005-2007 онд Удирдлагын академи
<b>Мэргэжил</b>	Бизнес удирдлага, Удирдахуйн ухааны мастер
<b>Ажиллаж байсан Байгууллага</b>	1990-1991 онд Хилийн цэргийн 151-р отряд, салбарын улс төрийн орлогч захирал 1992-1994 онд “Эрчим” ХЭАА захирал 1994-1996 онд “Кактус” ХХК захирал 2000-2004 онд Монгол Голландын хамтарсан “Грийн прожект” ХХК захирал
<b>Гадаад хэлний мэдлэг</b>	Хятад Орос



## 9. Ч.УЛАМБАЯР

Төрсөн он сар  
Төрсөн газар  
Гэр бүлийн байдал  
Боловсрол

Мэргэжил  
Ажиллаж байсан  
Байгууллага

Гадаад хэлний мэдлэг

1945  
Ховд аймаг, Булган сум  
Ам бүл 2.  
Монгол улсын их сургууль, УБИС Багш  
эдийн засагч  
Багш-эдийн засагч  
Нийгмийн аюулаас хамгаалах яамны III  
газар, Засгийн газрын хэрэг эрхлэх газар,  
БСБ сервис компани,  
Орос

## САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/төгрөгөөр/

№	Балансын зүйл	Аудитлагдсан	
		2014 оны 12-р сарын 31	2015 оны 12-р сарын 31
1	<b>ХӨРӨНГӨ</b>		
1.1	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ</b>		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	175,412,667.91	4,669,872.29
1.1.2	Дансны авлага	240,252,163.32	238,329,306.35
1.1.6	Бараа материал	464,754,243.69	656,695,544.52
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	-	224,199,080.00
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө	-	-
<b>1.1.11</b>	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>880,419,074.92</b>	<b>1,123,893,803.16</b>
1.2	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ</b>		
1.2.1	Үндсэн хөрөнгө	7,750,887,979.74	7,662,428,963.50
1.2.2	Биет бус хөрөнгө	69,662,613.47	629,805,746.70
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө	1,203,056,856.29	1,446,798,487.07
1.2.10	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>9,023,607,449.50</b>	<b>9,739,033,197.26</b>
<b>1.3</b>	<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>9,904,026,524.42</b>	<b>10,862,927,000.42</b>
2	<b>ӨР ТӨЛБӨР</b>		
2.1.1.1	Дансны өглөг	111,904,649.01	466,300,564.86
2.1.1.3	Татварын өр	63,364,092.21	134,329,419.17
2.1.1.4	НДШ - ийн өглөг	42,240.00	8,439,206.17
2.1.1.5	Богино хугацаат зээл	256,971,975.80	204,193,918.81
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг	217,358,332.50	206,179,632.50
2.1.1.13	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>649,641,289.52</b>	<b>1,019,442,741.51</b>
2.1.2.1	Урт хугацаат зээл	997,164,711.91	852,173,757.72
2.1.2.6	<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>997,164,711.91</b>	<b>852,173,757.72</b>
<b>2.2</b>	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>1,646,806,001.43</b>	<b>1,871,616,499.23</b>
	<b>ЭЗДИЙН ӨМЧ</b>		
2.3	Өмч	7,998,880,200.00	7,998,880,200.00
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал	209,680,202.10	209,680,202.10
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	-	668,826,110.40
2.3.9	Хуримтлагдсан ашиг	48,660,120.90	113,923,988.69
2.3.11	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>8,257,220,523.00</b>	<b>8,991,310,501.19</b>
<b>2.4</b>	<b>Өр төлбөр ба эздийн өмчийн дүн</b>	<b>9,904,026,524.43</b>	<b>10,862,927,000.43</b>

## ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

/төгрөгөөр/

№	Үзүүлэлтүүд	Аудитлагдсан	
		2014 оны 12-р сарын 31	2015 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	<b>3,759,722,401.65</b>	<b>2,937,598,797.06</b>
2	Борлуулалтын өртөг	<b>3,346,421,187.95</b>	<b>2,602,566,428.67</b>
<b>3</b>	<b>Нийт ашиг ( алдагдал)</b>	<b>413,301,213.70</b>	<b>335,032,368.39</b>
8	Бусад орлого	4,471,561.94	522,816.93
9	Борлуулалт, маркетингийн зардал	103,990,138.92	71,497,335.19
10	Ерөнхий ба удирдлагын зардал	262,600,414.52	191,967,572.70
11	Санхүүгийн зардал	25,430,226.70	-
12	Бусад зардал	200,000.00	-
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	482,114.44	367,040.37
<b>18</b>	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>26,034,109.94</b>	<b>72,457,317.80</b>
19	Орлогын татварын зардал	2,623,410.99	7,193,450.00
<b>20</b>	<b>Татварын дараахь ашиг (алдагдал)</b>	<b>23,410,698.95</b>	<b>65,263,867.80</b>
<b>22</b>	<b>Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал)</b>	<b>23,410,698.95</b>	<b>65,263,867.80</b>

## АУДИТЫН ХОРООНЫ ДҮГНЭЛТ

Аудитын хороо нь 2015 онд үүргийнхээ дагуу “Женко тур бюро” ХК-ийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажилласан. Бид Компанийн тухай хууль, Хувьцаат компанийн дүрмийг удирдлага болгон хяналт шалгалт хийх эрх, үүргийнхээ дагуу тус компанийн үйл ажиллагаанд ээлжит шалгалтыг төлөвлөгөөний дагуу явууллаа.

Шалгалтаар компанийн ТУЗ-ийн хурлаас гаргасан шийдвэрийн биелэлт, эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, зарцуулалт, хувь нийлүүлэгчдийн хурлын шийдвэрийн хэрэгжилтийг албан ёсны бичиг баримтанд тулгуурлан шалгаж, үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн гүйцэтгэлийг төсөв, төлөвлөгөөтэй харьцуулан, төлөвлөгөөний биелэлт, тайлангийн үзүүлэлтүүдэд дүн шинжилгээ хийж дүгнэлт гарган ажиллав.

АУДИТЫН ХОРООНЫ ДАРГА

Б.БАТБААТАР



## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2015 онд компанийн Төлөөлөн удирдах зөвлөл нь Аудитын

хороо, Цалин урамшууллын хороо, Нэр дэвшүүлэх хороо гэсэн

3 дэд хороонд үйл ажиллагаагаа уялдуулж, 6 энгийн, 3 хараат

бус гишүүнтэйгээр нийт 3 удаа хуралдаж дараах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэн байна. Үүнд:

- 2015 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны тайлан, төлөвлөгөөг хэлэлцэн баталсан.
- 2015 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлан, төлөвлөгөөг хэлэлцэн баталсан.
- 2015 оны жилийн эцсийн үйл ажиллагааны тайланг хэлэлцэн баталсан.
- 2015 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг хэлэлцэн баталсан.
- 2016 оны Үйл ажиллагааны болон санхүүгийн төсөв төлөвлөгөөг хэлэлцэн баталсан.

## АУДИТЫН ДҮГНЭЛТ



НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛ, ТАТВАР, САНХҮҮГИЙН ХЯНАЛТ  
БАТАЛГААЖУУЛАЛТЫН ИТГЭМЖЛЭГДСЭН ХӨНДЛӨНГИЙН БАЙГУУЛЛАГА

**“Ай Жэй Эй Эйч-Аудит” ХХК**

2016 он 03 сар 03 өдөр

№ 87/2016/АА

Улаанбаатар хот

**ЖЕНКО ТУР БЮРО ХК-ийн ТУЗ,  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭД**

### ХАРААТ БУС АУДИТЫН ТАЙЛАН

#### Санхүүгийн тайлангийн талаар

Бид “ЖЕНКО ТУР БЮРО” ХК-ний 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн Санхүүгийн байдлын тайлан, энэ өдөр тасалбар болсон Ашиг, Алдагдал болон Бусад дэлгэрэнгүй орлогын тайлан, Өмчийн өөрчлөлтийн тайлан, Мөнгөн гүйлгээний тайлан ба бусад тайлбар тодруулуудаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

#### Санхүүгийн тайлангийн талаархи компанийн удирдлагын хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (“СТОУС”)–ын дагуу бэлтгэж, шударгаар иж бүрэн толилуулах үүрэгтэй. Үүнд санхүүгийн тайлангуудын алдаа юм уу заль мэхнээс үүдэлтэй материаллаг буруу илэрхийллээс ангид бэлтгэж, шударгаар толилуулахуйц дотоод хяналтыг тогтоож, ажиллуулан, хэвийн түвшинд сахих, тохиромжтой нягтлан бодох бүртгэлийн бодлогыг сонгож, хэрэглэх, нөхцөл байдалд тохирсон нягтлан бодох бүртгэлийн тооцоолол хийх үүрэг хариуцлага багтдаг.

#### Аудиторын хүлээх хариуцлага

Бид гүйцэтгэсэн аудитдаа тулгуурлан эдгээр санхүүгийн тайланд дүгнэлт гаргах үүрэгтэй. Бид аудитаа Нягтлан Бодогчдын Олон Улсын Холбооноос батлан гаргасан Аудитын Олон Улсын Стандартын дагуу хийж гүйцэтгэлээ. Эдгээр стандарт нь санхүүгийн тайланд материаллаг зөрчилгүй илэрхийлэгдсэн эсэх талаарх зохих нотолгоог олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, ёс зүйн шаардлагуудыг баримтлан гүйцэтгэхийг биднээс шаарддаг. Аудитын ажил нь санхүүгийн тайлан дахь дүн болон тодруулгын үндэслэлийг төстийн үндсэн дээр шалгаж батлах ажлыг багтаадаг. Санхүүгийн тайлан нь алдаа эсвэл залилангийн улмаас гарч болох материаллаг буруу тайлагналтай байж болох эрсдлийг үнэлэх зэрэг горимуудыг аудитор өөрийн шийдлээр сонгож авна. Тэдгээр эрсдлийн үнэлгээг хийхэд байгууллагын дотоод хяналтын системийн үр нөлөөтэй байдлын талаар дүгнэлт гаргах зорилгоор биш харин тухайн нөхцөл байдалд зохистой аудитын горимуудыг зохиохын тулд санхүүгийн тайлангуудыг бэлтгэх, үнэн зөв танилцуулахтай холбоотой дотоод хяналтыг аудитор авч үздэг. Түүнчлэн аудитын ажил нь санхүүгийн бүртгэлийн зарчмуудыг шалгах ажлыг өөртөө агуулдаг. Бидний хийсэн аудитын ажил нь эдгээр санхүүгийн тайланд дүгнэлт гаргах хангалттай үндэслэл болж чадна гэж үзлээ.

## 2016 ОНЫ ТӨСӨВ ТӨЛӨВЛӨГӨӨ

### Аудиторын дүгнэлт

Бидний дүгнэлтээр, хавсаргасан Санхүүгийн тайлангууд нь “ЖЕНКО ТУР БЮРО” ХК-ийн 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал, энэ өдрөөр тасалбар болсон тайлант жилийн санхүүгийн гүйцэтгэл, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-ын дагуу үнэн зөв шударгаар илэрхийлсэн байна.

### Тайлангийн хэрэглээ

Энэхүү тайланг Монгол Улсын “Компанийн тухай хууль”-ийн 94-р зүйлд заасан хуулийн этгээд болох “ЖЕНКО ТУР БЮРО” ХК-ийн удирдлага, хувьцаа эзэмшигчдэд зориулж бэлтгэсэн. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.



“Ай Жэй Эй Эйч Аудит” ХХК

Улаанбаатар хот, Монгол Улс  
Тусгай зөвшөөрөл: 090-2010

Огноо: 2016.03.03

	Үзүүлэлт	Төсвийн дүн
Борлуулалт	Чингис Хааны Морьт Хөшөө цогцолборын борлуулалт	1,230,100
	13-р зуун цогцолборын борлуулалт	492,000
	Гадаад аяллын борлуулалт	1,356,210
	Дотоод аяллын борлуулалт	393,020
	<b>Нийт борлуулалтын орлого</b>	<b>3,471,330</b>
Өртөг	Чингис Хааны Морьт Хөшөө цогцолборын өртөг /шууд зардал/	880,302
	13-р зуун цогцолборын өртөг /шууд зардал/	488,532
	Гадаад аяллын өртөг /шууд зардал/	1,253,422
	Дотоод аяллын өртөг /шууд зардал/	245,300
	<b>Нийт өртөг / шууд зардал /</b>	<b>2,867,556</b>
Нийт ашиг	Чингисийн хөшөө цогцолборын нийт ашиг	349,799
	13-р зуун цогцолборын нийт ашиг	3,468
	Гадаад аяллын нийт ашиг	102,788
	Дотоод аяллын нийт ашиг	147,720
	<b>Нийт ашиг</b>	<b>603,774</b>
	Удирдлагын зардал	365,685
	<b>Үйл ажиллагааны ашиг</b>	<b>238,089</b>
	Үйл а-ны бус бусад орлого /зарлага/	(3,010)
	<b>Татварын өмнөх ашиг /алдагдал/</b>	<b>235,080</b>
	Орлогын албан татварын зардал	23,497
	<b>Цэвэр ашиг /алдагдал/</b>	<b>211,583</b>





Тухлах газрыг та сонго  
Туулах замыг бид хөтөлө

Since 1997

Женко Тур Бюро ХК  
Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот Чингисийн өргөн чөлөө 5  
Баянгол зочид буудал, Баянгол зочид буудал оффис 4 тоот  
Утас: 976 - 7012-0202  
Факс: 976 - 321705  
Вэб сайт: [www.genco-tour.mn](http://www.genco-tour.mn)  
И-мэйл: [info@genco-tour.mn](mailto:info@genco-tour.mn)